



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар

Улаанбаатар сарын 5-ны өдөр

Дугаар 194

хот

ХИЛИЙН ЗААГИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, ~~Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар~~, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. /Энэ тогтоолын 2-р хавсралтад 3Г-ын 2014 оны 260, 3Г-ын 2015 оны 130-р тогтоолоор тус тус өөрчлөлт орсон. Энэ тогтоолын 2-р хавсралтын зарим хэсгийг 3Г-ын 2015 оны 199-р тогтоолоор шинэчлэн баталсан. 3Г-ын 2015 оны 289-р тогтоолоор 2-р хавсралтыг хүчингүй болсонд тооцсон. 3Г-ын 2015 оны 302, 3Г-ын 2016 оны 155-р тогтоолоор 1, 3-р хавсралтад тус тус өөрчлөлт орсон. 3Г-ын 2014 оны 281-р тогтоолоор 2, 3-р хавсралтад өөрчлөлт орсон/

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Байгаль орчин, аялал

Д.ЦОГТБААТАР

жуулчлалын сайд